

“Хэрэглэгчийн өдөр” хууль тогтоомжийн сурталчилгаа , мэдээллийн өдөрлөгийн тайлан

2018.06.18

Амардалай

- “Хэрэглэгчийн өдөр”-ийг тохиолдуулан төлөвлөгөө боловсруулан 2018 оны 06 сарын 15-ний өдөр “Хэрэглэгчийн өдөрлөг”-ийг амжилттай зохион байгуулав.




- Хэрэглэгчийн өдрөөр ЗДТГ-ын улсын бүртгэгч О.Улаанхүү “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах” тухай хууль тогтоомжийг сурталчилан гарын авлага брошур тараалаа.



- Нийгмийн даатгалын байцаагч Ц.Сосорбурам нь малчин даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль тогтоомжоор сургалт, сурталчилгаа зохион байгуулж тараах материал бэлтгэн тараалаа.
- Соёлын төвийн номын санч С.Оюунтуяа нь ард иргэдэд хэрэглэгч, үйлчлүүлэгчийн соёлын талаарх мэдлэг олгох мэдээллийг хийлээ.
- Төрийн банк, Хаан банк нь “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах” аяны хүрээнд хийсэн ажлын тайлангаа ард иргэддээ тайлагналаа.
- Мөн төрийн банк, хаан банк нь зээлийн үйлчилгээ, хүүхдийн хадгаламжын талаар тараах материал тарааж ажиллаа.

- Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б.Нямтуяа нь “Байгаль орчин, хог хаягдлын тухай хууль тогтоомжын талаар мэдээллийг бэлтгэн ард иргэдэд танилцуулж, гарын авлага материалыг тарааж ажиллаа.
- БЗӨБЦТС ХК нь ард иргэдэд салбарынхаа товч танилцуулгыг бэлтгэн ард иргэдээ үзүүлж, хэрэглэгчээс дуудлага хүлээн авах, дуудлага барагдуулах үйлчилгээний талаар мэдээлэл хийлээ.



- Мал эмнэлэг үржлийн тасгаас шүлхий өвчний тухай зөвлөмж, трипанасомаз өвчнөөс урьдчилан сэргийлэх, галзуу өвчний тухай брошур гарын авлага бэлтгэн тараалаа..
- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр “Хүүхэд хэрэглэгч” болон хэрэглэгчийн өдрийн хүрээнд орчин үеийн хоол үйлдвэрлэлийн технологийг харилцан суралцах, хоол үйлдвэрлэлийн нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлчилгээний салбарын мэргэжлийн боловсон хүчний мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор хоол үйлдвэрлэгчийн дунд “Хүүхдийн хоолны зөв сонголт” хоолны үзэсгэлэнг зохион байгуулах ажлын удирдамж боловсруулж, батлуулан, хоол үйлдвэрлэгч, гал тогоо бүхий байгууллагад хүргүүлж, үзэсгэлэнг Соёлын төвийн байгууллагатай хамтран зохион байгуулж ажилалаа.



- Хоолны үзэсгэлэнд иргэнээс Ш.Должин, Хүүхдийн цэцэрэг, Хүн эмнэлгийн тогооч нар оролцож, 24 нэр төрлийн хоолоор үзэсгэлэн гаргаж, удирдамжийн дагуу “Шилдэг тогооч”, “Хамгийн олон нэр төрлийн хоол үйлдвэрлэгч” “Хэрэглэчийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч” гэсэн 3 төрлөөр шалгаруулж шагнаж урамшууллаа.



- “Хүүхэд хэрэглэгч” аяныг тохиолдуулан хүнсний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор хүнсний чиглэлээр худалдаа үйлчилгээ эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамж боловсруулан Засаг даргаар батлуулж, Байгаль орчны байгцаагч Б.Нямтуяа, НБ-ын мэргэжилтэн Ц.Хадамдарам, МЭҮТ-ийн мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Д.Наранцэцэг нар урьдчилсан сэргийлэх хяналт шалгалтыг хийж ажилалаа.



- “Хүүхэд хэрэглэгч” аяны хүрээнд ЗДТГ-ын зүгээс зайрмагны баяр зохион байгууллаа. Зайрмагны баярт нийт 240 хүүхэд хамрагдлаа.



Мөн хуулийн сургалтынхаа төгсгөлд ард иргэд, албан хаагчдынхаа дунд “Алтан хонх” танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд нийт 22 хүн оролцсоноос 3.Наранмандах тэргүүн байранд шалгарлаа.

Дэлгэрцогт сумын “Эрх зүйн хөтөч” баг